



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 07 сарын 02 өдөр

Дугаар A/40

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын 1.3.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болгон хөгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медикал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад орон тооны хамт шилжүүлэх, өр авлагын асуудлыг судлах үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.


2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсэг ажиллахад шаардагдах зардлыг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын холбогдох эх үүсвэрээс гаргасугай.

4.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медикал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хөрөнгө шилжүүлэх асуудлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



• 132003227

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2025 оны 07 дүгээр сарын 01-ны өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

А/40

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч	Д.Нарангэрэл	/Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга/
Гишүүд:	Ч.Саранцэцэг	/Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн/
	Э.Мөнхсүх	/Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын газрын дарга/
	Б.Одгэрэл	/Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга/
	М.Адилсайхан	/Хавдар, судлалын үндэсний төвийн ерөнхий захирал/
	Б.Батмагнай	/"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Зэс, металлын группын менежер/
	Э.Эрдэнэсүх	/"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Нэгдлийн хууль, эрх зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга/
	Ч.Хүрэлбаатар	/"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Бүртгэл, тайлагналын хэлтсийн ахлах нягтлан бодогч/
	А.Цээнэ	/"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Хууль, эрх зүйн мэргэжилтэн/
	Х.Болдбаатар	/"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Хуулийн хэлтсийн дарга/
	Т.Очирхүү	/"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга/

Р.Очбадрах

/”Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Төлөвлөлт,
эдийн засгийн шинжилгээний хэлтсийн
дарга/

Нарийн бичгийн
дарга

М.Баярмаа

/Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн мэргэжилтэн/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2025 оны 07 дүгээр сарын 02-ны өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг: Зорилго. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 204 дүгээр тогтоолын 1.3.3-т заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медикал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэх ажлын хүрээнд Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл.

1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөд тооллого хийж, санхүүгийн тайлантай тулган баталгаажуулалт хийх, акт үйлдэх, хөрөнгө хүлээн авах эрх хүлээн авагчид шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

2. Төсвийн болон бусад өр төлбөр, ажиллагсадтай хийх өр, авлагын тооцоог хийж актаар баталгаажуулах;

3. Орон тоог шилжүүлэн авах, тэдгээртэй холбоотой санхүүгийн тооцоо гаргах, цалин, хөлс, нийгмийн даатгалыг тасалдуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахад дэмжлэг үзүүлэх, ажилтнуудын нийгмийн баталгаа, эрх зүйн байдлыг дордуулахгүй байх арга хэмжээ авах;

4. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дуусаагүй худалдан авалт, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, судалгаа шинжилгээний бүтээл зэргийн эрхийг холбогдох хууль журмын дагуу хүлээлцэх;

5. Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад шилжүүлж, эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулах;

6. Архив, албан хэргийн материалыг акт үйлдэн эрх хүлээн авагчид шилжүүлэн өгөх;

7. Санхүүгийн хаалтын тайлан тэнцэл гаргах;

Гурав: Хугацаа, үр дүн. Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медикал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хөрөнгө шилжүүлэх ажлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэх.

----- о О о -----